

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдээ эрүүл мэндийн шалтгаант санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, хүн амын бодит хэрэгцээнд тулгуурласан тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн тогтолцооны зорилтуудыг хангах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд хуулийн төслийг баталснаар улсын төсөвт 9 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүснэ гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр хуулийн төслийн хүрээнд иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шатлалыг хэрхэн тодорхойлсон талаар, өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйлчилгээг сайжруулах болон улсын эмнэлэгт ажиллаж буй эмч нарыг сэлгэн ажиллуулах зохицуулалт туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хуулийн төслийг боловсруулахад суурь судалгаа хийгдсэн эсэх, судалгааны дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрлийг хэрхэн тодорхойлж, ангилсан талаар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталдаг төлбөрийн аргуудыг хуулийн төсөлд шууд тусгасан нь оновчтой эсэх, эмнэлгийн тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг орхигдуулсан талаар, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалт болон хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боловсруулж буй эрүүл мэндийн холбогдох бусад хуулийн төслүүдтэй хэрхэн уялдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тооцоолол, дэд бүтэц, өрх, сум, тосгоны

эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны стандарт, бүтцийн өөрчлөлтийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа эрүүл мэндийн салбарын тогтолцоог эмч, эмнэлэг төвтэй биш иргэний эрх ашигт нийцсэн байхаар хуулийн төслийг боловсруулсан талаар санал хэлсэн.


Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 75 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 68.8 хувийн саналаар, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



П.ГАНЗОРИГ